



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/181

Булган сум

Тусгай зөвшөөрлийн тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.2 дахь зүйлийн 1.1, 8 дугаар бүлгийн 8.1 дэх зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 40 дүгээр зүйлийн 40.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах цэгийн нэрсийг хавсралтаар баталж, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн 15.7-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн тоог батлах хүртэлх хугацаагаар сунгасугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл” сунгахад хураах тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
 03 дугаар сарын 27-ны өдрийн А/З дугаар
 захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЦЭГИЙН НЭРС

Д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр	Тохирлын үнэлгээтэй эсэх
1	2	3	4	5	6	7
1	Баяннуур	"Эх баян дэлгэрэх хоршоо"	М.Хандаа	Баар	"Буянт"	Тохирлын гэрчилгээтэй
2	Булган	"Анхдагч аян" ХХК	Б.Дүгэрмаа	Хүнсний дэлгүүр	"Нутгийн дэлгүүр"	Тохирлын гэрчилгээтэй
3		"Анхдагч аян" ХХК	Б.Дүгэрмаа	Баар	"Нутгийн зоог"	Тохирлын гэрчилгээтэй
4		"Булган маргад" ХХК	Л.Диваасүрэн	Хүнсний дэлгүүр	"Маргад"	Тохирлын гэрчилгээтэй
5		"Өнгөт Оч" ХХК	А.Мөнгөнсаран	Хүнсний дэлгүүр	"Чандмань"	Тохирлын гэрчилгээтэй
6		Бүрэгхангай	"Өгөөж дархан хангай" ХХК	Ц.Нарангарав	Хүнсний дэлгүүр	"Нарлаг хангай"
7	Сайхан	"Аргуун номт" ХХК	Б.Цэрэндорж	Хүнсний дэлгүүр	"Жаран цөнгөрөг"	Тохирлын гэрчилгээтэй
8	Хялганат тосгон	"Хялганат гэсэр хоршоо"	А.Хасбазар	Хүнсний дэлгүүр	"Дөл"	Тохирлын гэрчилгээтэй
9	Хишиг-Өндөр	"Отгийн бэл" ХХК	Р.Пүрэвмаа	Хүнсний дэлгүүр	"Цэцэг-Өндөр"	Тийм
10	Хишиг-Өндөр	"Хавтгайн бэл" ХХК	Ө.Чинбат	Хүнсний дэлгүүр	"Хөшөөт гол"	Тохирлын гэрчилгээтэй
11	Тэшиг	"Жаргалант тэшиг" ХХК	С.Батжаргал	Хүнсний дэлгүүр	"Тэнгис"	Тохирлын гэрчилгээтэй
12	Рашаант	"Сансар Арвижах" ХХК	П.Уянгажаргал	Баар	"Караоке баар"	Тохирлын гэрчилгээтэй
13	Рашаант	"Сансар Арвижах" ХХК	П.Уянгажаргал	Хүнсний дэлгүүр	"Мини маркет"	Тохирлын гэрчилгээтэй
	Нийт					